

**ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН 2023 ОНЫ  
ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ,  
ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.2 дахь заалтад “Засгийн газар хуулиар тусгайлан эрх олгосон тохиолдолд хуульд нийцүүлэн бүрэн эрхийнхээ хүрээнд хэм хэмжээний акт гаргаж болох бөгөөд тогтоол хэлбэртэй байна. Засгийн газар хэм хэмжээний акт гаргахдаа тусгайлан эрх олгосон хуулийг иш үндэс болгоно.” гэж заасны дагуу Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.4 дэх заалтыг үндэслэн Засгийн газраас 2020 онд “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам” /цаашид “нийтлэг журам” гэх/-ыг 206 дугаар тогтоолоор, энэ тогтоолыг үндэслэн Хууль зүй, дотоод хэргийн сайдаас 2022 онд “Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээний агентлаг, байгууллагын хяналт-шинжилгээний, үнэлгээ хийх журам” /цаашид “салбарын журам” гэх/-ыг А/107 дугаар тушаалаар тус тус баталж мөрдүүлсэн.

Цагдаагийн ерөнхий газрын 2023 оны үйл ажиллагаанд үнэлгээ хийхэд захиргааны байгууллагын үйл ажиллагаанд бодлогын баримт бичиг<sup>1</sup>, хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн хэрэгжилт<sup>2</sup>, Монгол Улсын хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт туссан Засгийн газрын тэргүүлэх ач холбогдолтой төсөл, арга хэмжээг үнэлэх шалгуур үзүүлэлтийн биелэлт, эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлтийн биелэлт, стратеги төлөвлөгөөний биелэлт, байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт, ил тод байдлыг хангах талаар хэрэгжүүлсэн үйл ажиллагаа, шилэн дансны хөтлөлт, шударга байдлыг хангах талаар хэрэгжүүлсэн үйл ажиллагаа, Монгол Улсын Засгийн газрын зарим чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх гэрээний хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт, төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн биелэлт, хэрэглэгчийн үнэлгээний тайлан гэсэн 11, салбарын журамд нэмж, Хууль зүй, дотоод хэргийн сайд, дэд сайд, Төрийн нарийн бичгийн даргын тушаалаар өгсөн үүрэг даалгавар, сайдын шуурхай хуралдаанаас өгсөн үүрэг, даалгавар гэсэн 2, нийт 13 үйл ажиллагааг хамааруулсан.

Эдгээр үйл ажиллагаа, бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийг тайлант оны эхнээс хяналтад авч, хэрэгжилтийг тайлант оны туршид зохион байгуулан, тайлант оны 12 дугаар сарын 05-ны өдрөөр тасалбар болгон хэрэгжилтийг тооцож, үр дүнг үнэлж, хүснэгтээр үзүүлэв. Үүнд:

Үзүүлэлт		Хувь	Жин	Оноо
1	2	3	4	5
Бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн үнэлгээ	1.Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт	100	0.6	4.8
	2.Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт	99.0		

<sup>1</sup> Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 4.1.4-4.1.14, 9.6.5 заасан баримт бичгүүд.

<sup>2</sup> Нийтлэг журмын 3.2.2.1-3.2.2.9-д заасан баримт бичгүүд.

	3.Монгол Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний биелэлт	90.0		
	4.Салбарын хөгжлийн үзүүлэлтийн үнэлгээ	100.0		
Байгууллагын чиг үүргийн үзүүлэлтийн үнэлгээ	1.Байгууллагын тухайн жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт	98.8	0.2	
	2.Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн биелэлт	100		
Байгууллагын нээлттэй байдлын үнэлгээ	1.Байгууллагын ил тод байдлын үнэлгээ	96.9	0.2	
	2.Шилэн дансны хөтлөлтийн үнэлгээ	95.6		
	3.Шударга байдлын түвшний үнэлгээ	73.6		
	4.Хэрэглэгчийн үнэлгээ	93.0		
ЕРӨНХИЙ ҮНЭЛГЭЭ:		96.1	1.0	

Цагдаагийн ерөнхий газрын 2023 оны үйл ажиллагаанд нийтлэг журмын дагуу хяналт-шинжилгээ хийж, үр дүнг журмын 6.2.1-д заасан аргачлалаар тооцож, 6 дугаар хавсралтад зааснаар үйл ажиллагааны үнэлгээг дүгнэхэд “Бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн үнэлгээ” 97.2 хувь, “Байгууллагын чиг үүргийн үзүүлэлтийн үнэлгээ” 99.4 хувь, “Байгууллагын нээлттэй байдлын үнэлгээ” 89.8 хувь, ерөнхий дүн буюу “Байгууллагын үйл ажиллагааны үнэлгээний дүн” 96.1 хувь, 4.8 оноотой байна.

Хяналт-шинжилгээ, үнэлгээнд хамруулсан үйл ажиллагаанаас хууль тогтоомж, тогтоол шийдвэр, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, Монгол Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө, “Алсын хараа 2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр, Гэрч, хохирогчийг хамгаалах, туслалцаа үзүүлэх үндэсний хөтөлбөр, Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх хөтөлбөрийн хэрэгжилт, стратеги төлөвлөгөө болон байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө, сайдын шуурхай хуралдаанаас өгсөн үүрэг, даалгаврын биелэлт, Монгол Улсын Засгийн газрын зарим чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх гэрээний хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө, Хууль зүй, дотоод хэргийн сайд, дэд сайд, Төрийн нарийн бичгийн даргын тушаалаар өгсөн үүрэг даалгаваргүй тул хариуцан хяналт-шинжилгээ, үнэлгээ хэрэгжүүлэгчээс гарсан санал, өгсөн зөвлөмжгүй.

## ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР